

ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО



2017

БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ТАНИЛЦУУЛГА



Улаанбаатар хот
2018 он

АГУУЛГА

БҮЛЭГ I. БОЛОВСРОЛЫН СТАТИСТИК

1.1 Боловсролын тухай ойлголт	5
1.2 Боловсролын статистикийн үзүүлэлтүүд, тэдгээрийн ашиглалт	6
1.3 Хүн амын бичиг үсгийн мэдлэг	6

БҮЛЭГ II. БҮХ ШАТНЫ СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГА

2.1 Сургуулийн өмнөх боловсрол	8
2.2 Ерөнхий боловсролын сургууль	11
2.2.1 Суралцагчид	13
2.2.2 Суралцагчдын насны ангилал	17
2.2.3 Нэгдүгээр ангид шинээр элсэгч	17
2.2.4 СӨБ болон ЕБС-ийн хамран сургалт	18
2.2.5 Үндсэн багш	19
2.3 Мэргэжлийн боловсрол	18
2.4 Дээд боловсрол	
2.4.1 Дээд боловсролын сургалтын байгууллага	21
2.4.2 Дээд боловсролын сургуульд суралцагчдын тоо	23
2.4.3 Суралцагчдын мэргэжлийн чиглэл	25
2.4.4 Шинээр элсэгчдийн тоо	26
2.4.6 Дотуур байранд амьдарч байгаа оюутнуудын тоо	26
2.4.6 Сургалтын төлбөрийн дундаж хэмжээ	27
2.4.7 Дээд боловсролын сургалтыг төгсөгчид	25
2.5 Бүх шатны боловсролын байгууллагыг төгсөгчид	

БҮЛЭГ III. ДҮГНЭЛТ

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Цэцэрлэг, цэцэрлэгийн хүүхдийн тоо, 1960-2017 он	9
Зураг 2. Ясли, яслийн хүүхдийн тоо, 1988-2017 он	9
Зураг 3. Сургуулийн өмнөх боловсролын байгууллага, өмчийн хэлбэр, дүнд эзлэх хувиар	10
Зураг 4. Сургуулийн өмнөх боловсрол (СӨБ)-д хамрагдсан хүүхдийн тоо, хувиар.....	10
Зураг 5. СӨБ-д хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо, хөгжлийн бэрхшээлийн хэлбэрээр	11
Зураг 6. Ерөнхий боловсролын сургууль (ЕБС), түүнд суралцагчдын тоо, 1925-2017 он	12
Зураг 7. Ерөнхий боловсролын сургуулийн тоо, өмчийн хэлбэрээр.....	12
Зураг 8. Ерөнхий боловсролын сургуулийн тоо, хот, хөдөөгөөр.....	13
Зураг 9. Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчид, сургалтын хэлбэрээр.....	13
Зураг 10. Ерөнхий боловсролын сургуулийн гадна байгаа 6-14 насны хүүхэд, 2017/2018 оны хичээлийн жилээр	14
Зураг 11.Ерөнхий боловсролын сургуулийн гадна байгаа 6-14 насны хүүхэд, шалтгаанаар, дүнд эзлэх хувиар, 2017/2018 оны хичээлийн жилээр.....	15
Зураг 12. ЕБС-д суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, хувиар.....	16
Зураг 13. Ерөнхий боловсролын сургуульд өдрөөр суралцагчдын тоо, насны ангиллаар	17
Зураг 14. Нэгдүгээр ангид шинээр элссэн суралцагчид, өмчийн хэлбэрээр	18
Зураг 15. Хамран сургалтын бохир жин, 2009-2017 он	18
Зураг 16. Хамран сургалтын цэвэр жин, 2009-2017 он.....	19
Зураг 17. Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн тоо, өмчийн хэлбэрээр	20
Зураг 18. Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн тоо, түүнд суралцагчид, 1990-2017 он.....	21
Зураг 19. Дээд боловсролын сургалтын байгууллагын тоо, түүнд суралцагчид, 1940-2017 он.....	21
Зураг 20. Дээд боловсролын сургалтын байгууллагын тоо, өмчийн хэлбэрээр	22
Зураг 21. Дээд боловсролын сургалтын байгууллагын тоо, ангиллаар	22
Зураг 22. Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид, өмчийн хэлбэрээр.....	23
Зураг 23. Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид, ангилал, дүнд эзлэх хувиар	24
Зураг 24. Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид, хүйс, боловсролын зэрэг, дүнд эзлэх хувиар	24
Зураг 25. Дээд боловсролын сургалтын байгууллагад шинээр элсэгчдийн тоо	26

Зураг 26. Дээд боловсролын сургалтын байгууллагыг төгсөгчид, боловсролын зэргээр.....	28
Зураг 27. Бүх шатны сургалтын байгууллагыг төгсөгчид, мянган хүн	28

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Сургууль завсардсан хүүхэд, насны бүлэг, шалтгаанаар, 2017/2018 оны хичээлийн жилээр	15
Хүснэгт 2. Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байранд амьдарч байгаа суралцагчид, бүс, аймаг, нийслэлээр, 2000, 2005-2017 он	16
Хүснэгт 3. Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн багш	19
Хүснэгт 4. Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид, мэргэжлийн чиглэлийн чиглэлээр	25
Хүснэгт 5. Дотуур байранд амьдардаг оюутнуудын тоо.....	26
Хүснэгт 6. Бакалаврын өдрийн сургалтын төлбөрийн жилийн дундаж хэмжээ, мянган төгрөг	27

I. БОЛОВСРОЛЫН СТАТИСТИК

1.1. БОЛОВСРОЛЫН ТУХАЙ ОЙЛГОЛТ

Боловсролын олон улсын ангилал¹ (ISCED)-д тодорхойлсноор боловсрол нь хүний сурч боловсрох хэрэгцээг хангахад чиглэсэн, урьдчилан нарийвчилж төлөвлөсөн, системтэй үйл ажиллагаанаас бүрдэнэ. Боловсролын үйл ажиллагаа нь эрдэм мэдлэг (*learning*) олгоход чиглэсэн зохион байгуулалттай, тасралтгүй үргэлжлэх харилцаа холбоо (*communication*) юм.

Харилцаа холбоо гэдэг нь мэдээлэл солилцох (бичиг захидал, санаа, мэдлэг, стратеги гэх мэт) үйл ажиллагаанд оролцож байгаа хоёр буюу түүнээс дээш хүмүүсийн хоорондын харилцаа юм. Харилцаа нь аман, аман бус, шууд/нүүр тулсан ярилцлага юмуу шууд бус/зайны гэсэн хэлбэртэй байж болох ба мөн хэвлэл мэдээллийн янз бүрийн сувгуудыг өргөнөөр ашигласан байж болно. Мэдлэг олголт нь хүмүүсийн зан төлөв/хүмүүжил, мэдээлэл, мэдлэг, ойлголт, хандлага, ур чадварт гарч буй сайжралт/дэвшлийг хэлнэ.

Монгол Улсын “Боловсролын тухай” хуулийн 4 дүгээр зүйлд “Монгол Улсын боловсролын зорилго нь иргэнийг оюун ухаан, ёс суртахуун, бие бялдрын зохих чадавхитай, хүмүүнлэг ёсыг дээдлэн сахидаг, бие даан сурах, ажиллах, амьдрах чадвартай болгон төлөвшүүлэхэд оршино” гэж заажээ. Түүнчлэн энэ хуульд зааснаар манай улсын боловсролын үндсэн зарчим нь:

- Боловсролыг тэргүүлэх салбар болгон хөгжүүлж, төрийн ивээл, зохицуулалт, төр, олон нийтийн хяналтад байлгана;
- Монгол Улсад боловсрол нь хүмүүнлэг, ардчилсан, тасралтгүй, бүх нийтэд хүртээмжтэй байх бөгөөд үндэсний болон хүн төрөлхтөний соёл иргэншлийн үнэт зүйлс, дэвшилт өв уламжлал, шинжлэх ухаанд тулгуурлана;
- Боловсрол эзэмшүүлэх арга, хэлбэр, суралцагчийн хэрэгцээ, хувийн болон хөгжлийн онцлогт нийцсэн олон хувилбартай, чөлөөтэй, нээлттэй байна;
- Иргэнийг сурч боловсроход үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, хөгжлийн онцлог, эрүүл мэнд, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодлоор нь ялгаварлан гадуурхахгүй байх, эх хэлээрээ сурч боловсрох нөхцлөөр хангана;
- Нийгэм, иргэний эрх ашиг, эрүүл мэнд, аюулгүй байдалд сөрөг нөлөө бүхий гадаад улсын санхүүжилт, зохион байгуулалттайгаар шашны чиглэлээр сургалт, шашны зан үйл, бусад үйл ажиллагааны сургалт зохион байгуулахыг хориглоно;
- Өмчийн төрөл, хэлбэрийг харгалзахгүйгээр боловсролын байгууллагад адил тэгш хандана гэж заажээ.

Монгол Улсын “Боловсролын тухай” хуульд заасны дагуу манай улсын боловсролын тогтолцоо нь албан ба албан бус боловсролын нэгдэл байх бөгөөд сургуулийн өмнөх болон бага, дунд, мэргэжлийн боловсрол, дээд боловсролоос бүрдэнэ.

Боловсролын түвшин: Тухайн шатанд эзэмшвэл зохих сургуулийн өмнөх, бага, дунд, дээд боловсролын агуулгын стандартаар тогтоосон мэдлэгийн хэмжээг.

¹ Олон Улсын Боловсролын ангилал

Албан боловсрол: Боловсролын албан ёсны байгууллагаар дамжуулж, суралцагчийн ерөнхий болон мэргэжлийн зохих түвшний боловсрол эзэмших хэрэгцээг хангадаг боловсролын зохион байгуулагдсан үйл ажиллагаа.

Албан бус боловсрол: Боловсролын албан ёсны тогтолцооноос гадуур иргэнд боловсролын үйлчилгээ үзүүлэх зохион байгуулалттай үйл ажиллагаа.

Насан туршийн боловсрол: Бүх насны иргэд боловсролын албан болон албан бус хэлбэрээр ёс суртахуун, гоо зүй, иргэн, гэр бүл, шинжлэх ухаан, амьдрах ухааны боловсролыг тасралтгүй эзэмших үйл ажиллагааг ойлгоно.

1.2. БОЛОВСРОЛЫН СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, ТЭДГЭЭРИЙН АШИГЛАЛТ

Боловсролын статистик нь хүний амьдралын чанарын болон улс орны хөгжлийн чухал үзүүлэлтүүдийг бүрдүүлдэг. Боловсролын салбарын статистикийн мэдээллийн гол эх үүсвэр нь БСШУСЯ болон ХНХЯ-ны захиргааны статистикийн мэдээлэл байдаг. Түүнчлэн 10 жил тутам явагддаг ХАОСТ болон өрхөд суурилсан түүвэр судалгаанууд (АХС, ӨНЭЗС, НҮТС гэх мэт)-аас боловсролын статистикийн үзүүлэлтийг тооцон гаргаж байна.

Боловсролын статистикийн захиргааны мэдээллийг тогтоосон хугацаанд цэцэрлэг, бүх шатны сургуулиас цуглуулан авдаг. Боловсролын мэдээллийн хамрах хүрээний хувьд төрийн болон өмчийн бусад хэлбэрийн бүх сургалтын байгууллагуудыг хамардаг бөгөөд батлагдсан маягтаар мэдээллийг цуглуулж, жилийн бюллетень, танилцуулга, эмхэтгэлд тусган нийтэд хүргэж байна.

Боловсролын статистикийн мэдээллийг Засгийн газрын мөрийн хөтөлбөр боловсруулах, хэрэгжилтийг дүгнэх, салбарын нэмэгдэл өртгийн тооцоо хийх, хүлээгдэж буй гүйцэтгэлийг тооцох, тогтвортой хөгжлийн зорилт, бүх нийтийн боловсрол (*Education for all*) хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтүүд, хүний хөгжлийн үзүүлэлтүүдийг тооцоход ашиглаж байгаагаас гадна ЮНЕСКО-гоос жил бүр гаргадаг эмхэтгэлд боловсролын салбарын хүртээмжийн 10, дотоод үр ашгийн 8, үр дүнгийн 13, санхүүгийн болон хүний нөөцийн 10, нийт 41 үзүүлэлтийг ЮНЕСКО-гоос боловсруулсан аргачлалын дагуу тооцон оруулж байна.

1.3. ХҮН АМЫН БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ

Бичиг үсгийн мэдлэг нь хүний эрхийн хамгийн чухал хэсэг бөгөөд чанартай суурь боловсрол нь бичиг үсгийн мэдлэгтэй хүүхдийг цаашдын амьдрал, сургалт боловсролд хөтөлдөг бол бичиг үсгийн мэдлэгтэй, боловсролтой эцэг эхчүүд хүүхдээ эрүүл чийрэг өсгөж, сургуульд суралцуулах боломжийг илүү бүрдүүлдэг. Түүнчлэн нэгдмэл, боловсролтой ард түмэн хөгжлийн тулгамдсан асуудлууд, сорилтыг давах, шийдвэрлэх хүчирхэг хүч болдог².

Ямар нэг боловсрол эзэмшээгүй ч аль нэг хэлээр хамгийн энгийн богино өгүүлбэрийг уншиж, ойлгож, бичих чадвартай хүнийг бичиг үсэг мэддэг хүн гэж үздэг.

Энэ үзүүлэлтийг тооцож буй зорилго нь хүн амын тэр дундаа насанд хүрэгчдийн оюуны потенциалын өсөлт, түүний нийгэм, эдийн засаг, соёлын хөгжилд оруулж буй хувь нэмрийг харуулна. Энэ үзүүлэлт нь тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд бага боловсролын хамралт ямар

² "International Literacy Statistics: Review of Concepts, Methodology and Current Data", UNESCO, 2008

байгааг харуулах бөгөөд утга нь өндөр байвал хүн амын дийлэнх хувь нь бичиг үсгийн мэдлэгээ өдөр тутмын амьдралдаа хэрэглэхээс гадна цааш үргэлжлүүлэн суралцах боломжтой, ингэснээр нийгмийн гишүүний тухайн нутаг дэвсгэрийн хөгжилд оруулах хувь нэмэр нэмэгдэнэ гэдгийг илэрхийлдэг учраас уг үзүүлэлтийг хүн амын боловсролын талаарх бодлого, төлөвлөлтөд ашигладаг.

Бичиг үсгийн мэдлэгийн түвшинг “Хүн ам, орон сууцны тооллого”-ын мэдээллээс гаргадаг бөгөөд хүн амын 1918 оны тооллогын дүнгээс Монголчуудын бичиг үсэг, боловсролтой холбоотой тодорхой тоо баримт байхгүй байна.

Манай улсын хүн амын боловсролын түвшин хамгийн их өсөлттэй үе нь 1969-1979 он байсан бөгөөд сүүлийн хоёр тооллогын хооронд хамгийн бага өсөлттэй байгаа нь төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн нийгмээс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжиж, мэргэжлийн сургалт төлбөртэй болсонтой холбоотой байж болох юм.

Арав, түүнээс дээш насны хүн амд боловсролтой хүн амын эзлэх хувь “Хүн ам, орон сууцны 2010 оны тооллого”-оор өмнөх тооллогын дүнгээс 4.1 пунктээр нэмэгдэж, 92.5 хувь болсон байна. Улсын болон хувийн хэвшлийн олон их, дээд сургууль байгуулагдаж, түүнд олон арван мянган залуучууд суралцан, төгсөж байгаагийн дүнд 10, түүнээс дээш насны нийт хүн амд дээд боловсролтой хүний эзлэх хувь өнгөрсөн 11 жилд 10.6 пунктээр нэмэгдсэн нь нэг талаар сайн үзүүлэлт боловч нөгөө талдаа үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт ажиллах дунд болон мэргэжлийн боловсрол эзэмшигчдийн хувь буурсан байна.

Боловсрол эзэмшигчдийг хүйсээр ангилж үзэхэд нэлээд ялгаатай байдал ажиглагдана. Ялангуяа, дээд боловсролтой эрэгтэйчүүдийн эзлэх хувь тооллого хооронд 2.0 дахин нэмэгдсэн байхад эмэгтэйчүүдийнх 2.8 дахин нэмэгджээ. Гэтэл тусгай мэргэжлийн дунд, мэргэжлийн боловсрол эзэмшигчдийн хувь буурсаны дотор эмэгтэйчүүдийнх нь эрэгтэйчүүдийнхээс илүү буурсан байна. Арав, түүнээс дээш насны нийт хүн амд боловсролгүй хүн амын эзлэх хувь нэлэнхүйдээ буурсаны дотор эмэгтэйчүүдийнх илүү буурчээ.

Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогоор хүн амын боловсролын түвшинг хот, хөдөөгөөр ангилж үзэхэд ялгаатай тал харагдаж байна. Хот, хөдөөгийн хүн амын боловсролын түвшин дээшлэх тутам боловсролын ялгаа нь нэмэгдэж байна. Боловсролгүй хүний эзлэх хувь хөдөөд хотоос 2.7 дахин их бол дээд боловсролтой хүн ам хөдөөгийнхөөс 3.3 дахин их байна. Харин хотод бүрэн дунд боловсролтой хүн ам олон байхад хөдөөд суурь болон бага боловсролтой хүн илүү олон байна. Хөдөөд дээд, тусгай мэргэжлийн дунд боловсролтой эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жин эрэгтэйчүүдийнхээс өндөр, суурь болон бага боловсролтой эрэгтэйчүүдийн эзлэх хувь эмэгтэйчүүдийнхээс илүү байгаагаас үзэхэд хөдөөгийн эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээсээ илүү өндөр боловсролтой байна. Хотод мөн адил энэ байдал ажиглагдаж байна.

II. БҮХ ШАТНЫ СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГА


Монгол Улсын “Боловсролын тухай” хуульд зааснаар “сургалтын байгууллага” гэж боловсролын нэг буюу хэд хэдэн түвшний боловсролын агуулгыг хэрэгжүүлдэг хуулийн этгээдийг хэлнэ гэж тодорхойлсон байдаг.

2.1. СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛ

“Сургуулийн өмнөх боловсролын тухай” хуульд зааснаар “хүүхдийн цэцэрлэг” гэж хоёр наснаас сургуульд элсэх хүртэлх насны хүүхдийг асрах, хамгаалах, хөгжүүлэх цогц үйл ажиллагаа бүхий сургалтын байгууллагыг хэлнэ.


Цэцэрлэгийн тоо 1960 оноос хойш жил бүр өссөөр 1990 онд 909 болсон нь 1960-2011 оны хугацаан дахь хамгийн өндөр өсөлттэй үзүүлэлт байсан. 2012 оноос манай улсын цэцэрлэгийн тоо, цэцэрлэгт хамрагдах хүүхдийн тоо жил бүр өсөн нэмэгдсээр байна.

Зураг 1. Цэцэрлэг, цэцэрлэгийн хүүхдийн тоо, 1960-2017 он




Сургуулийн өмнөх боловсролын зорилго нь бага насны хүүхдийг өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжин, насан туршийн боловсролын суурь чадварыг эзэмшихэд дэмжин асрах, хамгаалах, хөгжүүлэх, сургалт, үйл ажиллагаагаар сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд оршдог бөгөөд энэ зорилгыг хэрэгжүүлэхэд яслийн гүйцэтгэх үүрэг их байдаг. 1988-1991 онд яслын тоо өндөр өсөлттэй байсан бөгөөд 1992 оноос огцом буурсаар 2017/2018 оны хичээлийн жилд яслийн 115 бүлэг ажиллаж, түүнд 2674 хүүхэд хүмүүжиж байгаа нь өмнөх оны хичээлийн жилийнхээс яслид хамрагдсан хүүхдийн тоо 267-гоор өссөн үзүүлэлттэй байна.

Зураг 2. Ясли, яслийн хүүхдийн тоо, 1988-2017 он



Монгол Улсын хэмжээнд 2017/2018 оны хичээлийн жилд нийт хүүхдийн 1416 цэцэрлэг үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс төрийн өмчийн 878 (62.0%) цэцэрлэг (төмөр замын харьяа хүүхдийн 27 цэцэрлэг), хувийн 538 (38.0%) цэцэрлэг байна. Үйл ажиллагаа явуулж байгаа цэцэрлэгийн тоо өмнөх оноос 62 (төрийн 24 (2.8%), хувийн 38 (7.6%))-оор нэмэгдсэн байна.


Зураг 3. Сургуулийн өмнөх боловсролын байгууллага, өмчийн хэлбэрээр, дүнд эзлэх хувиар



Улсын хэмжээн дэх нийт 538 хувийн цэцэрлэгийн 434 буюу 80.7 хувь нь Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байна. Энэ хичээлийн жилд нийслэлд хувийн цэцэрлэгүүд 27-гоор

нэмэгдсэн байна. Харин нийт цэцэрлэгийн 48.6 хувь нь нийслэл Улаанбаатар хотод байрлаж байгаа бөгөөд өмнөх оноос 1.8 пунктээр өссөн байна.


Зураг 4. Сургуулийн өмнөх боловсрол (СӨБ)-д хамрагдсан хүүхдийн тоо, хувиар



Хувилбарт сургалтад 23705 буюу 9.7 хувь нь хамрагдаж байгаа нь өмнөх оноос 0.5 пунктээр буурсан байна. Хувилбарт сургалтад хамрагдсан хүүхдүүдийн 4636 нь ээлжийн бүлэгт, 16291 нь нүүдлийн бүлэгт, 2778 нь явуулын багшийн үйлчилгээгээр дамжуулан сургуулийн өмнөх боловсролыг эзэмшсэн байна.

Цэцэрлэгийн үндсэн сургалтад хамрагдаж байгаа хүүхдийг бүлгээр нь авч үзвэл: яслийн бүлэгт 2674 (1.1%), бага бүлэгт 46950 (20.2%), дунд бүлэгт 53957 (23.2%), ахлах бүлэгт 59061 (25.3%), бэлтгэл бүлэгт 59268 (25.4%), холимог бүлэгт 11105 (4.8%) хамрагдаж байна. Сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан нийт хүүхдийн 29493 буюу 11.5 хувь нь малчдын хүүхэд байна.

Зураг 5. СӨБ-д хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо, хөгжлийн бэрхшээлийн хэлбэрээр




Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй нийт хүүхдийн тоо 2017/2018 оны хичээлийн жилд 1597 болж, өмнөх оноос 84 хүүхдээр өссөн үзүүлэлттэй байна. Дээрх зургаас харахад оюун ухааны (16.5%) болон хавсарсан (41.6%) хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо өсөж, харин бие эрхтэний бэрхшээлтэй хүүхдийн тоо (12.9%) буурсан байна. Түүнчлэн СӨБ-д хамрагддаг хүүхдүүдээс 152 (0.1%) нь бүтэн өнчин хүүхэд байна. Бүтэн өнчин хүүхдийн тоо өмнөх оны хичээлийн жилээс 25 (19.7%)-аар өссөн байна.

2.2. ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ

Монгол Улсын “Боловсролын тухай” хуульд зааснаар “бүх нийтийн ерөнхий боловсрол” гэж 12 жилийн сургалтын агуулгын түвшинг, “суурь боловсрол” гэж 9 жилийн сургалтын агуулгын түвшинг ойлгодог. Бага, дунд боловсролын сургалтын байгууллага нь ерөнхий боловсролын сургууль юм.

Зураг 6. Ерөнхий боловсролын сургууль (ЕБС), түүнд суралцагчдын тоо, 1925-2017 он




Монгол Улсад анхны сургууль 1925 онд байгуулагдаж байсан бөгөөд өнөөг хүртэл тасралтгүй өсөн нэмэгдсээр байгаа нь дээрх зургаас харагдаж байна. 2017/2018 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 798 сургууль ажиллаж байгаагийн 74 (9.3%) нь бага сургууль, 116 (14.5%) нь дунд сургууль, 562 (70.4%) нь ахлах сургууль, 46 (5.8%) нь цогцолбор сургууль байна.

ЕБС-ийн тоог өмнөх онтой харьцуулахад, ахлах сургуулийн тоо 20 (3.7%), бага сургуулийн тоо 5 (7.2%)-аар тус тус өсөж, дунд сургуулийн тоо 1 (0.9%), цогцолбор сургуулийн тоо 4 (8.0%)-өөр тус тус буурсан байна.


Ерөнхий боловсролын 798 сургууль сургалтын үйл ажиллагаа эрхэлж байгаагийн 81.7 хувь нь төрийн өмчийн, 18.3 хувь нь хувийн өмчийн сургууль байна.

Зураг 7. Ерөнхий боловсролын сургуулийн тоо, өмчийн хэлбэрээр



Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн 56 (8.6%) нь бага, 115 (17.6%) нь дунд, 440 (67.5%) нь ахлах, 41 (6.3%) нь цогцолбор сургууль байна. Хувийн сургуулийн 18 (12.3%) нь бага, 1 (0.7%) нь дунд, 122 (83.6%) нь ахлах, 5 (3.4%) нь цогцолбор сургуулийн ангилалд тус тус багтаж, сургалтын үйл ажиллагаа эрхэлж байна.

Зураг 8. Ерөнхий боловсролын сургуулийн тоо, хот, хөдөөгөөр




Нийт сургуулийн 69.8 хувь буюу 557 нь хөдөөд, 30.2 хувь буюу 241 нь хотод сургалтын үйл ажиллагаа эрхэлж байна.

2.2.1. Суралцагчид

2017/2018 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуульд нийт 581.2 мянган (өдрөөр 572752, оройгоор 111, эчнээгээр 350, дүйцсэн хөтөлбөрөөр 7947) суралцагчид суралцсан байна. Нийт суралцагчдын тоо өнгөрсөн оны хичээлийн жилээс 19467-гоор, үүнээс өдрөөр суралцагчид 20799-өөр өссөн бол, эчнээгээр суралцагч 97-гоор, оройгоор суралцагч 66-гаар, дүйцсэн хөтөлбөрөөр суралцагч 1169-өөр тус тус буурсан байна.

Зураг 9. Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчид, сургалтын хэлбэрээр




Өдрөөр суралцагчдын 50.1 хувь нь хөвгүүд, 49.9 хувь нь охид байна. Харин бага ангийн нийт сурагчдын 48.9 хувь, дунд ангийн сурагчдын 49.6 хувь, ахлах ангийн сурагчдын 54.3 хувийг охид эзэлж байна. Хүйсийн ялгааны индекс 1.0 байгаа бөгөөд энэ нь 100 эрэгтэй сурагчид 100 эмэгтэй сурагч ногдож байна гэсэн үг юм.

Өдрөөр суралцагчдын 93.9 хувь нь төрийн өмчийн сургуульд, 6.1 хувь нь хувийн сургуульд суралцаж байна. Өмнөх оны хичээлийн жилтэй харьцуулахад бага ангийн суралцагчдын тоо 7.3 хувиар, дунд ангийн сурагчид 5.3 хувиар тус тус өссөн бол ахлах ангийн суралцагчдын тоо 9.4 хувиар буурсан байна.

Малчдын хүүхдүүд нийт суралцагчдын 19.1 хувийг эзэлж байгаа нь өмнөх оны хичээлийн жилээс 0.2 пунктээр өссөн байна. ЕБС-д 2017/2018 оны хичээлийн жилд гадаад улсын харьяат 687 хүүхэд суралцсан байна.


ЕБС-ийн гадна байгаа 6-14 насны хүүхдийн тоо 682 байгаа нь өмнөх оныхоос 237 хүүхдээр өсжээ. Сургуулийн гадна байгаа нийт хүүхдийн 219 буюу 32.1 хувь нь эмэгтэй суралцагчид байна.

Зураг 10. Ерөнхий боловсролын сургуулийн гадна байгаа 6-14 насны хүүхэд, 2017/2018 оны хичээлийн жилээр



2017/2018 оны хичээлийн жилд ЕБС-ийн гадна байгаа хүүхдүүдийн 161 (23.6%) нь амьдралын гачигдлаар, 222 (32.6%) нь өвчний улмаас, 255 (37.4%) нь шалтгаан тодорхойгүй, 35 (5.1%) нь суралцах хүсэлгүй, 9 (1.3%) ажил эрхлэхээр сургууль завсардсан байна.

Зураг 11. Ерөнхий боловсролын сургуулийн гадна байгаа 6-14 насны хүүхэд, шалтгаанаар, дүнд эзлэх хувиар, 2017/2018 оны хичээлийн жилээр




2017/2018 оны хичээлийн жилд сургууль завсардсан 682 хүүхэд байгаагийн 514 (75.4%) нь сургуульд огт ороогүй, 168 (24.6%) нь сургуульд ороод завсардсан хүүхэд байна. Сургууль завсардсан хүүхдүүдийг насны ангиллаар авч үзвэл, 6-11 настай хүүхэд 520 (76.2%), 12-14 настай хүүхэд 162 (23.8%) байна.

Хүснэгт 1. Сургууль завсардсан хүүхэд, насны бүлэг, шалтгаанаар, 2017/2018 оны хичээлийн жилээр

Шалтгаан	Бүгд	Сургуульд огт ороогүй						Сургуульд ороод завсардсан					
		6-11 настай			12-14 настай			6-11 настай			12-14 настай		
		Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Бүгд	682	462	278	184	52	40	12	58	47	11	110	98	12
Амьдралын гачигдлаас	161	98	64	34	3	3	-	15	14	1	45	41	4
Сурах хүсэлгүй	35	4	2	2	1	1	-	6	6	-	24	23	1
Ажил эрхлэхээр	9	7	4	3	-	-	-	-	0	-	2	2	-
Өвчний улмаас	222	131	74	57	40	31	9	28	20	8	23	18	5
Шалтгаан тодорхойгүй	255	222	134	88	8	5	3	9	7	2	16	14	2

Монгол Улсын “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай” хуульд “хөгжлийн бэрхшээлтэй хүн” гэж бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг хэлнэ гэж тодорхойлсон байдаг. Энэ хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуульд 7279 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцаж байна. Эдгээр хүүхдүүд нь нийт суралцагчдын 1.3 хувийг эзэлж, өмнөх оны хичээлийн жилээс 0.2 пунктээр буурсан байна.

Зураг 12. ЕБС-д суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, хувиар



Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байр 2017 онд 517 болж өмнөх оны хичээлийн жилээс 4-өөр нэмэгджээ. Дотуур байранд амьдрах хүсэлт гаргасан 38444 мянган хүүхдээс 35196 мянга нь дотуур байранд амьдарч байгаа нь өмнөх оны хичээлийн жилээс дотуур байранд амьдарч байгаа хүүхдийн тоо 598 буюу 1.7 хувиар өссөн байна.

Хүснэгт 2. Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байранд амьдарч байгаа суралцагчид, бүс, аймаг, нийслэлээр, 2000, 2005-2017 он


Аймаг, нийслэл	2000/2001	2005/2006	2006/2007	2007/2008	2008/2009	2009/2010	2010/2011	2011/2012	2012/2013	2013/2014	2014/2015	2015/2016	2016/2017	2017/2018
Улсын дүн	27 435	41 068	42 986	44 037	42 086	42 156	40 488	38 065	36 130	34 704	32 858	33 253	34 598	35 196
Баруун бүс	11 780	15 393	15 815	16 309	15 396	15 450	14 326	13 785	12 896	12 583	11 691	12 017	12 244	12 236
Баян-Өлгий	2 746	4 278	4 848	4 897	4 813	4 977	4 751	4 917	4 514	4 482	4 092	4 333	4 354	4 531
Говь-Алтай	3 725	3 317	2 428	2 537	2 263	2 269	2 077	1 874	1 708	1 610	1 443	1 553	1 604	1 491
Завхан	3 003	3 037	3 180	3 287	2 754	2 538	1 774	1 682	1 530	1 553	1 384	1 515	1 417	1 394
Увс	1 618	2 964	3 286	3 423	3 418	3 393	3 429	3 252	3 197	3 092	2 878	2 627	2 966	2 926
Ховд	688	1 797	2 073	2 165	2 148	2 273	2 295	2 060	1 947	1 846	1 894	1 989	1 903	1 894
Хангайн бүс	9 286	14 271	15 357	14 677	14 305	14 600	14 042	12 736	12 115	11 355	10 803	10 698	11 253	11 595
Архангай	2 048	2 737	2 954	2 914	2 832	2 884	2 817	2 537	2 430	2 258	2 040	2 247	2 232	2 313
Баянхонгор	1 340	2 200	2 271	2 364	2 263	2 201	1 976	1 976	1 711	1 599	1 560	1 720	1 743	1 710
Булган	1 200	1 895	1 900	1 976	1 911	1 906	1 873	1 778	1 726	1 635	1 571	1 572	1 714	1 794
Орхон	164	189	184	181	187	269	225	254	249	256	228	227	211	219
Өвөрхангай	2 110	3 125	3 163	2 811	2 811	2 813	2 813	2 257	2 152	2 115	2 099	2 124	2 042	2 085
Хөвсгөл	2 424	4 125	4 885	4 431	4 301	4 527	4 338	3 934	3 847	3 492	3 305	2 808	3 311	3 474
Төвийн бүс	3 827	7 176	7 544	7 912	7 390	7 356	7 152	6 828	6 721	6 499	6 285	6 352	6 699	6 634
Говьсүмбэр	307	98	103	108	85	80	162	152	160	146	146	135	165	149
Дархан-Уул	231	655	650	660	654	579	528	564	549	555	588	604	647	628
Дорноговь	1 303	807	919	923	841	866	905	828	843	865	863	859	856	813
Дундговь	617	1 100	1 069	1 089	980	1 088	1 009	1 001	982	923	807	758	821	965
Өмнөговь	956	1 545	1 626	1 594	1 471	1 386	1 178	1 117	1 094	1 004	962	942	1 001	868
Сэлэнгэ	376	912	1 057	1 401	1 314	1 421	1 434	1 296	1 230	1 131	1 114	1 221	1 189	1 191
Төв	37	2 059	2 120	2 137	2 045	1 936	1 936	1 870	1 863	1 875	1 805	1 833	2 020	2 020
Зүүн бүс	1 864	3 297	3 730	4 038	3 859	3 672	3 876	3 608	3 321	3 228	3 007	3 062	3 082	3 208
Дорнод	539	1 040	1 240	1 362	1 290	1 267	1 278	1 142	1 086	1 029	893	928	908	917
Сүхбаатар	849	1 254	1 181	1 297	1 288	1 185	1 176	1 118	1 033	950	921	978	864	924
Хэнтий	476	1 003	1 309	1 379	1 281	1 220	1 422	1 348	1 202	1 249	1 193	1 156	1 310	1 367
Улаанбаатар	678	931	540	1 101	1 136	1 078	1 053	1 082	1 057	1 023	1 048	1 103	1 279	1 486
Бусад ¹	-	-	-	-	-	-	39	26	20	16	24	21	41	37

¹ Бүгд Найрамдах Солонгос улс дахь Монгол сургуулийг хамруулав.

2.2.2. Суралцагчдын насны ангилал

Ерөнхий боловсролын сургуульд өдрөөр суралцагчдын 0.1 хувь нь сургуульд элсэх наснаасаа эрт элссэн бол 53.8 хувийг 6-10 настай, 29.2 хувийг 11-14 настай, 16.4 хувийг 15-17 настай, 0.5 хувийг 18, түүнээс дээш настай суралцагчид байна. Сургуулийн эрт элсэлт өмнөх оны хичээлийн жилээс 0.2 пунктээр, 11-14 настай суралцагчид 0.6 пунктээр, 15-17 настай суралцагчид 1.3 пунктээр, 18, түүнээс дээш настай суралцагчдын тоо 0.1 пунктээр тус тус буурсан бол 6-10 настай суралцагчдын тоо 2.2 пунктээр өссөн байна.

Зураг 13. Ерөнхий боловсролын сургуульд өдрөөр суралцагчдын тоо, насны ангиллаар




2.2.3. Нэгдүгээр ангид шинээр элсэгч

2017/2018 оны хичээлийн жилд нэгдүгээр ангид нийт 68238 хүүхэд элссэний 99.6 хувь (67974)-ийг шинээр элссэн суралцагчид эзэлж байна. Нэгдүгээр ангид шинээр элсэгчдийн тоог өмнөх оны хичээлийн жилтэй харьцуулахад 9.6 хувиар өссөн бөгөөд суралцагчдын 94.4 хувь нь төрийн өмчийн, 5.6 хувь нь хувийн сургуульд элсжээ.

Нийт шинээр элсэгчдийн 6.4 хувийг сургуульд элсэх наснаас хожуу насандаа элссэн суралцагч эзэлж байна. Нийт элсэгчдийн 64.6 хувь нь сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан бөгөөд өмнөх оны хичээлийн жилээс 3.7 пунктээр буурсан бол элсэгчдийн 35.4 хувь нь сургуульд элсэхийн өмнө сургуулийн өмнөх боловсролд хамрагдаагүй байна.

Зураг 14. Нэгдүгээр ангид шинээр элссэн суралцагчид, өмчийн хэлбэрээр




2.2.4. СӨБ болон ЕБС-ийн хамран сургалт

Хамран сургалтын бохир жинг тооцохдоо аль нэг боловсролын түвшинд нас харгалзалгүйгээр суралцагчдын тоог тухайн насны хүн амын тоонд харьцуулж, хувиар илэрхийлнэ.

Монгол Улсын сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтын бохир жин 2009-2010 онд 76.7 хувиас 77.6 хувь болж өссөн хэдий ч 2011 онд 74.6 хувь болж буурч, сүүлийн жилүүдэд харьцангуй тогтвортой байна.

Бага боловсролын (1-5 анги) хамран сургалтын бохир жин 2017/2018 оны хичээлийн жилд 98.6 хувь болж, өмнөх оны хичээлийн жилийнхээс 0.5 пунктээр буурч, дунд боловсролынх 103.3 хувь болж, өмнөх оны хичээлийн жилийнхээс 1.6 пунктээр өссөн байна.

Зураг 15. Хамран сургалтын бохир жин, 2009-2017 он




Хамран сургалтын цэвэр жинг тооцохдоо аль нэг боловсролын түвшний тухайн насны суралцагчдын тоог тухайн насны хүн амын тоонд харьцуулж, хувиар илэрхийлнэ.

Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтын цэвэр жин 2017/2018 оны хичээлийн жилд 79.8 хувь болж, өмнөх оны хичээлийн жилийнхээс 1.7 пунктээр өсжээ.

Бага боловсролын (1-5 анги) хамран сургалтын цэвэр жин 2009-2014 онд 94.3-99.1 хувь болж өсч байгаад 2015/2016 оны хичээлийн жилд буурсан хэдий ч 2017/2018 оны хичээлийн жилд 97.1 хувь болж, өмнөх оны хичээлийн жилийнхээс 0.2 пунктээр өссөн байна.

Дунд боловсролын (6-9 анги) хамран сургалтын цэвэр жин 2017/2018 оны хичээлийн жилд 95.1 хувь болж, өмнөх оны хичээлийн жилийнхээс 0.5 пунктээр буурсан байна.

Зураг 16. Хамран сургалтын цэвэр жин, 2009-2017 он



2.2.5. Үндсэн багш

Ерөнхий боловсролын сургуульд 29.2 мянган үндсэн багш ажиллаж байгаагийн 91.5 хувь нь төрийн өмчийн сургуульд, 8.5 хувь нь хувийн өмчийн сургуульд ажиллаж байна. Багшийн тоо өмнөх оны хичээлийн жилээс 353 (1.2%)-аар (төрийн өмчийн сургуулийн багш 215-аар, хувийн өмчийн сургуулийн багш 138-аар) нэмэгдсэн байна.

Хүснэгт 3. Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн багшийн тоо


Хичээлийн жил	Үндсэн багш	Өмчийн хэлбэрээр		Бага	Дунд	Ахлах
		Төрийн	Хувийн			
2013/2014	27 205	25 027	2 178	8 795	11 184	7 226
2014/2015	27 449	25 218	2 231	8 901	11 233	7 315
2015/2016	28 490	26 209	2 281	9 877	11 454	7 159
2016/2017	28 889	26 527	2 362	9 976	11 708	7 205
2017/2018	29 242	26 742	2 500	10 238	11 960	7 044

2.3. МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ

Монгол Улсын “Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай” хуульд “мэргэжил” гэж тодорхой ажил, хөдөлмөр эрхлэхэд шаардагдах мэдлэг, чадвар, дадлын цогцыг, “мэргэжлийн боловсрол” гэж тодорхой мэргэжлийн үйл ажиллагааг гүйцэтгэх хэрэгцээнд нийцүүлж зохион байгуулалттай сургалтаар эзэмшүүлсэн мэргэжлийн мэдлэг, ур чадвар, хөдөлмөрийн болон харилцааны соёлын төлөвшлийг хэлнэ гэж тодорхойлжээ.

Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага нь мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв юм. Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв (МСҮТ)-ийн тоо 2017/2018 оны хичээлийн жилд 83 болж, өмнөх оны хичээлийн жилээс 3-аар буурсан байна. Улсын хэмжээнд 2017/2018 оны хичээлийн жилд үйл ажиллагаа явуулж байгаа мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 60.2 хувь нь төрийн өмчийн, 39.8 хувь нь хувийн өмчийнх байна.


Зураг 17. Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн тоо, өмчийн хэлбэрээр



2017/2018 оны хичээлийн жилд мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд 35.8 мянган суралцагчид суралцаж байгаа нь өмнөх оны хичээлийн жилээс 4.3 мянгаар буурсан байна.

Төрийн өмчийн 50 сургуульд 25.7 мянган оюутан, хувийн өмчийн 33 сургуульд 10.1 мянган оюутан суралцаж байна. МСҮТ-ийн нийт суралцагчдын 61.1 хувийг эрэгтэйчүүд, 38.9 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна.

Зураг 18. Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн тоо, түүнд суралцагчид, 1990-2017 он




2.4 ДЭЭД БОЛОВСРОЛ

Манай улсын дээд боловсролын зорилго нь төрөөс боловсролын талаар баримтлах бодлогод тулгуурлан боловсролын үндсэн зарчим, олон улсын нийтлэг жишиг, хандлагад нийцүүлэн иргэнд дээд боловсрол олгоход оршино. Дээд боловсролын сургалтын байгууллага нь их сургууль, дээд сургууль, коллеж байна.

2.4.1. Дээд боловсролын сургалтын байгууллага


2017/2018 оны хичээлийн жилийн мэдээллээр Монгол Улсад дээд боловсролын 96 байгууллага сургалтын үйл ажиллагаа явуулж байна.

Зураг 19. Дээд боловсролын сургалтын байгууллагын тоо, түүнд суралцагчид, 1940-2017 он




2017/2018 оны хичээлийн жилд дээд боловсролын үйл ажиллагаа явуулж буй 96 байгууллагын 18.8 хувь нь төрийн, 78.1 хувь нь хувийн, 3.1 хувь нь гадаадын салбар сургууль байна.

Зураг 20. Дээд боловсролын сургалтын байгууллагын тоо, өмчийн хэлбэрээр



Дээд боловсролын сургалтын 96 байгууллагын 36.4 хувь нь их сургууль, 54.2 хувь нь дээд сургууль, 6.3 хувь нь коллежийн ангилалд багтаж, 3.1 хувь нь гадаадын салбар сургууль байгаа бөгөөд өмнөх хичээлийн жилтэй харьцуулахад их сургуулийн тоо 4 (12.9%)-өөр, коллежийн тоо 3 (2.0 дахин)-аар тус тус өсөж, дээд сургуулийн тоо 5 (8.8%)-аар, гадаадын салбар сургуулийн тоо 1 (25.0%)-ээр тус тус буурсан байна.

Зураг 21. Дээд боловсролын сургалтын байгууллагын тоо, ангиллаар




Дотоодын төрийн өмчийн 18 сургуулийн 14 (77.8%) нь их сургууль, 4 (22.2%) нь дээд сургууль байна. Хувийн өмчийн 75 сургуулийн 21 (28.0%) нь их сургууль, 48 (64.0%) нь дээд сургууль, 6 (8.0%) нь коллежийн ангилалд багтаж сургалтын үйл ажиллагаа явуулж байна.

2.4.2. Дээд боловсролын сургуульд суралцагчдын тоо

2017/2018 оны хичээлийн жилийн эхэнд их, дээд сургууль, коллежид суралцагчдын тоо 155248 болж, өмнөх хичээлийн жилээс 1890 (1.2%)-ээр буурчээ. Нийт суралцагчдын 89473 (57.6%) нь төрийн өмчийн, 65628 (42.3%) нь хувийн өмчийн, 147 (0.1%) нь гадаадын салбар сургуульд суралцаж байна.


Өмнөх оны хичээлийн жилээс төрийн өмчийн сургуулийн суралцагчдын тоо 2325 (2.5%)-аар, гадаадын салбар сургуулийн суралцагчдын тоо 118 (44.5%)-аар буурсан бөгөөд хувийн өмчийн сургуульд суралцагчдын тоо 553 (0.8%)-аар өссөн байна.

Зураг 22. Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид, өмчийн хэлбэрээр




Нийт суралцагчдын 88.0 хувь нь их сургуульд, 11.6 хувь нь дээд сургуульд, 0.3 хувь нь коллежид, 0.1 хувь нь гадаадын салбар сургуульд суралцаж байна. Өмнөх оны хичээлийн жилтэй харьцуулахад их сургуульд суралцагчдын эзлэх хувь 3.2 пунктээр, коллежид суралцагчдын эзлэх хувь 0.1 пунктээр тус тус өссөн бол дээд сургуульд суралцагчдын эзлэх хувь 3.2 пунктээр, гадаадын салбар сургуулиудад суралцагчдын эзлэх хувь 0.1 пунктээр тус тус буурсан байна.

Зураг 23. Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид, ангиллаар, дүнд эзлэх хувиар



Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдын 90094 (58.0%) нь эмэгтэй, 65154 (42.0%) нь эрэгтэй суралцагчид байна. Эндээс харахад 100 эрэгтэй суралцагчид 138 эмэгтэй ногдож байна.

Зураг 24. Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид, хүйс, боловсролын зэргээр, дүнд эзлэх хувиар



Боловсролын бүхий л зэргээр суралцагчдын дотор эмэгтэйчүүдийн эзлэх хувь давамгайлж байгаагаас магистрантурт суралцагч эмэгтэйчүүдийн эзлэх хувь бакалавр болон докторантурт суралцагчдынхаас арай илүү өндөр байна.

2.4.3. Суралцагчдын мэргэжлийн чиглэл

2014/2015 оны хичээлийн жилээс эхлэн бакалавр, магистрантур, докторантурт шинээр элсэгчдийн мэргэжлийн чиглэл, индексийг тодорхойлохдоо Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2014 оны А/78 болон А/370 дугаар тушаалуудаар батлагдсан мэргэжлийн чиглэл /хөтөлбөр/, индексийг, 2014/2015 оны хичээлийн жилээс өмнө элсэн суралцаж буй суралцагчдын хувьд тэдгээрийг төгстөл нь Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын “Мэргэжлийн чиглэл, индекс шинэчлэн тогтоох тухай” 2010 оны 235 дугаар тушаалын дагуу тухайн сургуулийн сургалт эрхлэх тусгай зөвшөөрөлд заасан мэргэжлийн чиглэл /хөтөлбөр/, индексийг мөрдөхөөр болсон.

2017/2018 оны хичээлийн жилд суралцагч оюутнуудын 20810 (13.4%) нь багш, сурган хүмүүжүүлэх, 12764 (8.2%) нь урлаг судлал ба хүмүүнлэгийн ухаан, 8903 (5.7%) нь хууль, эрх зүй, 7554 (4.9%) нь нийгмийн шинжлэл, 31498 (20.3%) нь худалдаа, бизнесийн удирдлага, 16853 (10.9%) нь нийтийн мэдээлэл, математик, компьютер, үйлчилгээ, байгалийн шинжлэл, 20722 (13.3%) нь анагаах ухаан, 17277 (11.1%) нь инженер, 8412 (5.4%) нь архитектур, хот төлөвлөлт, 10455 (6.7%) нь хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас агнуур болон бусад мэргэжлээр суралцаж байна.

Хүснэгт 4. Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид, мэргэжлийн чиглэлээр


Мэргэжлийн чиглэл	2010/2011	2011/2012	2012/2013	2013/2014	2014/2015	2015/2016	2016/2017	2017/2018
Бүгд	170 126	172 798	175 591	174 075	178 295	162 626	157 138	155 248
Багш, боловсрол судлал, сурган хүмүүжүүлэх	22 471	22 381	22 072	21 853	22 664	22 091	22 006	20 810
Хүмүүнлэгийн ухаан	11 610	11 176	9 737	8 506	8 034	7 108	7 099	7 931
Урлагийн төрөл, урлаг судлал	3 147	3 631	3 694	3 885	4 609	4 408	4 702	4 833
Хууль, эрх зүй	8 261	8 331	8 259	7 924	8 502	8 928	8 825	8 903
Нийгмийн шинжлэл	11 864	13 910	12 900	10 830	10 149	8 380	6 853	7 554
Худалдаа, бизнесийн удирдлага	36 375	36 514	37 688	39 153	38 105	34 555	33 134	31 498
Нийтийн мэдээлэл, бичиг хэрэг	2 149	2 295	2 330	2 253	2 351	1 938	1 346	1 482
Математик, компьютер	6 722	6 385	5 876	5 522	5 743	4 989	4 785	4 182
Үйлчилгээ	8 843	8 045	9 237	8 939	7 121	6 516	6 237	5 643
Байгалийн шинжлэл	5 210	5 570	5 906	5 903	7 413	6 161	5 073	5 546
Анагаах ухаан	17 995	15 973	17 575	19 226	20 687	19 141	18 540	20 722
Инженер	24 274	26 861	28 142	27 429	25 096	22 219	19 010	17 277
Архитектур, хот төлөвлөлт	5 710	5 752	5 558	6 448	7 990	8 720	8 247	8 412
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас агнуур	4 902	5 286	6 130	5 694	5 138	4 407	4 098	3 426
Бусад мэргэжил	593	688	487	510	4 693	3 065	7 183	7 029

Сүүлийн 8 жилийн мэдээнээс харахад, нийт оюутнуудын тоо буурсан байна. Харин 2017/2018 оны хичээлийн жилд багш, сурган хүмүүжүүлэх, худалдаа, бизнесийн удирдлага, математик, компьютер, үйлчилгээ, инженер, хөдөө аж ахуй, бусад мэргэжлээр суралцагчдын тоо тус тус буурсан бол харин бусад салбарын мэргэжлээр суралцагчдын тоо өссөн үзүүлэлттэй байна.

2.4.4. Шинээр элсэгчдийн тоо

Дээд боловсролын сургалтын байгууллагад 2017/2018 оны хичээлийн жилд 45480 оюутан шинээр элссэний 32919 буюу 72.4 хувийг тухайн жилд ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар ангийг төгсөж бүрэн дунд боловсрол эзэмшигчид эзэлж байна. Өнгөрсөн хичээлийн жилтэй харьцуулахад нийт шинээр элсэгчид 4285-аар, түүний дотор ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар ангийг төгсгөгчдөөс элсэгчдийн тоо 5293-аар өсжээ.

Зураг 25. Дээд боловсролын сургалтын байгууллагад шинээр элсэгчдийн тоо



2.4.5. Дотуур байранд амьдарч байгаа оюутнуудын тоо

2017/2018 оны хичээлийн жилийн эхний байдлаар 14841 оюутан дотуур байранд амьдрахаар хүсэлт гаргасны 14378 (96.9 %) нь дотуур байранд амьдарч байна. Дотуур байранд амьдарч байгаа оюутнуудын 13640 (94.9%) нь сургуулийнхаа дотуур байранд, 738 (5.1%) нь бусад сургуулийн дотуур байранд амьдарч байна. Дотуур байранд амьдарч буй оюутнуудын тоог өмнөх оны хичээлийн жилтэй харьцуулахад өссөн үзүүлэлттэй байна. Тухайлбал, дотуур байранд амьдрахаар саналаа өгсөн оюутнуудын тоо 2251-ээр, дотуур байранд амьдарч байгаа оюутнуудын тоо 2004-өөр тус тус өсжээ.

Хүснэгт 5. Дотуур байранд амьдардаг оюутнуудын тоо

Үзүүлэлт	2013/2014	2014/2015	2015/2016	2016/2017	2017/2018
Дотуур байранд суухаар саналаа өгсөн	17 192	14 123	11 740	12 590	14 841
Дотуур байранд амьдарч байгаа	14 229	12 748	11 058	12 374	14 378
Эмэгтэй	9 687	8 887	7 962	8 904	10 340
Дотуур байрны хангалт	82.8	90.3	94.2	98.3	96.9
Сургуулийнхаа дотуур байранд амьдарч байгаа	12 701	11 865	9 774	11 198	13 640

2.4.6. Сургалтын төлбөрийн дундаж хэмжээ

2017/2018 оны хичээлийн жилийн жилд төрийн өмчийн сургуулийн бакалаврын өдрийн сургалтын төлбөрийн жилийн дундаж хэмжээ 2034.1 мянган төгрөг, харин хувийн өмчийн сургуулийнх 2215.3 мянган төгрөг байна. Үүнийг өмнөх оын хичээлийн жилтэй харьцуулахад төрийн өмчийн сургуулийн сургалтын төлбөр 6.3 хувиар, хувийн өмчийн сургуулийнх 13.5 хувиар тус тус нэмэгджээ.

Хүснэгт 6. Бакалаврын өдрийн сургалтын төлбөрийн жилийн дундаж хэмжээ, мянган төгрөг

Үзүүлэлт	2013/2014	2014/2015	2015/2016	2016/2017	2017/2018
Төрийн өмчийн сургуульд	1 149.8	1 490.1	1 688.0	1 913.0	2 034.1
Хувийн өмчийн сургуульд	1 292.3	1 595.1	1 842.3	1 952.2	2 215.3
Төрийн ба хувийн өмчийн сургуулийн дундаж	1 221.1	1 542.6	1 765.2	1 932.6	2 124.7
Өмнөх оын хичээлийн жилтэй харьцуулсан өсөлтийн хувь (%):					
Төрийн өмчийн сургуульд	24.8	29.6	13.3	13.3	6.3
Хувийн өмчийн сургуульд	18.1	23.4	15.5	6.0	13.5

Сүүлийн 5 жилийн мэдээнээс харахад, бакалаврын өдрийн сургалтын төлбөрийн жилийн дундаж хэмжээ өмчийн хэлбэрээс үл хамааран жил бүр нэмэгдсэн бөгөөд 2017 онд 2013 оныхоос төрийн өмчийн сургуулийнх 1.8 дахин, хувийн өмчийн сургуулийнх 1.7 дахин өссөн

байна. Хувийн өмчийн сургуулийн сургалтын төлбөрийн хэмжээ төрийн өмчийн сургуулийнхаас өндөр байна. Сургалтын төлбөрийн хэмжээ боловсролын зэрэг, сургалтын хэлбэрээсээ хамаарч өөр өөр байгаа бөгөөд тухайлбал, магистрантур, докторантурын сургалтын төлбөр бакалаврын сургалтынхаас харьцангуй өндөр байна.

2.4.7 Дээд боловсролын сургалтыг төгсөгчид

2017/2018 оны хичээлийн жилд 29164 оюутан суралцагч төгсөж өмнөх хичээлийн жилээс 5517 (15.9%)-гоор буурсан байна. Төгсөгчдийн боловсролын зэргээр өсөлт, бууралтыг өнгөрсөн оны хичээлийн жилийнхтэй харьцуулж үзвэл, магистр 96-гаар, доктор 18-аар тус тус нэмэгдсэн бол дипломын дээд 450-аар, бакалавр 5181-ээр тус тус буурсан байна. Нийт төгсөгчдийн 45 (0.2%) нь дипломын дээд, 25120 (86.1%) нь бакалавр, 3868 (13.3%) нь магистр, 131 (0.4%) нь докторын зэргээр төгссөн байна.


Зураг 26. Дээд боловсролын сургалтын байгууллагыг төгсөгчид, боловсролын зэргээр



2.5 БҮХ ШАТНЫ СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫГ ТӨГСӨГЧИД

2017/2018 оны хичээлийн жилд бүх шатны сургалтын байгууллагыг нийт 135.1 мянган суралцагчид төгссөн бөгөөд өмнөх оны хичээлийн жилээс 8.6 мянгаар өссөн үзүүлэлттэй байна.

Зураг 27. Бүх шатны сургалтын байгууллагыг төгсөгчид, мянган хүн



III. ДҮГНЭЛТ

- ✓ 2017/2018 оны хичээлийн жилд цэцэрлэгийн тоо 1416, хамрагдаж буй хүүхдийн тоо 256.7 мянга болж, өмнөх оны хичээлийн жилээс цэцэрлэгийн тоо 4.6 хувиар, цэцэрлэгийн хүүхдийн тоо 5.5 хувиар тус тус нэмэгдсэн байна.
- ✓ ЕБС-ын өдрөөр суралцагчдын 93.9 хувь нь төрийн өмчийн сургуульд, 6.1 хувь нь хувийн өмчийн сургууль суралцаж байна. Хүйсийн ялгааны индекс 1.0 байгаа нь 100 эрэгтэй сурагчид 100 эмэгтэй сурагч ногдож байна.
- ✓ Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд суралцагчид 2017/2018 оны хичээлийн жилд 35.8 мянга, дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид 155.2 мянга болсон нь сүүлийн жилүүдэд буурах хандлагатай байна.
- ✓ Хөгжиж буй ихэнх улс, орнуудад гол төлөв боловсрол доогуур буюу боловсролгүй хүн ам ажилгүй байдаг бол манай улсад боловсролын түвшин дээшлэх тутам ажилгүй байх магадлал өндөр байгаа бөгөөд “Ажиллах хүчний судалгаа”-ны 2017 оны үр дүнгээс харахад, ажилгүй иргэдийн 34.7 хувийг техникийн болон мэргэжлийн боловсролтой иргэд, 30.3 хувийг дипломын дээд болон бакалаврын зэрэгтэй иргэд эзэлж байна.
- ✓ Дээрх үзүүлэлтийг хүйсээр авч үзвэл, техникийн болон мэргэжлийн боловсролтой ажилгүй иргэдийн 44.3 хувь нь эрэгтэйчүүд, 21.3 хувь нь эмэгтэйчүүд байгаа бол дипломын дээд болон бакалаврын зэрэгтэй ажилгүйчүүдийн 21.9 хувь нь эрэгтэйчүүд, 41.9 хувь нь эмэгтэйчүүд байна.
- ✓ Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээ болон боловсролын системийн үйл ажиллагаа, сургалтын хөтөлбөрийн хоорондын уялдаа, мөн сургуулиудын мэргэжлийн

чиглэлийг шинэ тутам хөгжиж байгаа бизнесийн салбар, чиглэлүүд, техник, технологийн хөгжлийн хоорондын уялдаа, зохицуулалт байхгүйгээс мэргэжил, боловсролтой ч тухайн ажилд тохирохгүй байгаа нь ажилгүйдэл нэмэгдэх нэг шалтгаан болох талтай юм.

- ✓ Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдын 42.0 хувь нь эрэгтэйчүүд, 58.0 хувь нь эмэгтэйчүүд байгаа нь 100 эрэгтэйд 138 эмэгтэй ногдож байна.
- ✓ 2017/2018 оны хичээлийн жилд сургуулийн гадна байгаа хүүхдүүдийн 67.9 нь эрэгтэй хүүхэд байгаа бөгөөд цаашид энэ үзүүлэлт нэмэгдвэл мэргэжлийн сургалтын байгууллагад суралцагчдын хүйсийн тэнцвэрт бус байдал улам нэмэгдэж, эдийн засгийн төрөл бүрийн салбарт ажиллах мэргэжилтэй боловсон хүчин ялангуяа ажил үйлдвэрлэлийн онцлог нь эрэгтэйчүүд голлон ажиллах аж ахуйн нэгж, байгууллагад ажиллагчид хүрэлцээгүй болж болох талтайг анхаарч, мэргэжлийн сургуулиудад суралцагчдын мэргэжлийн онцлогийг харгалзан хүйсийг төлөвлөгөөтэйгээр зохицуулах шаардлагатайг анхаарах хэрэгтэй байна.
- ✓ Түүнчлэн шүүхээр ял шийтгүүлсэн хүмүүсийн 63.1 хувь нь бүрэн дундаас дээш боловсролтой байгааг ч анхаарах шаардлагатай байна.

.....оО о.....